

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2020

Арвайхээр хот 2020 о



АГУУЛГА

| | |
|---|-------------------------------------|
| ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ | 3 |
| УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР | Error! Bookmark not defined. |
| БҮЛЭГ-1 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ | Error! Bookmark not defined. |
| 2.1. Орон нутгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгдсэн тайланд хийсэн аудит | 7 |
| 2.2. Төсвийн төвлөрүүлэн захирагчдын санхүүгийн тайланд хийсэн аудит | 7 |
| 2.3. Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайланд хийсэн аудит | 8 |
| 2.4. Засгийн газрын тусгай сангуудын санхүүгийн тайланд хийсэн аудит | 8 |
| 2.5. Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуй нэгжийн санхүүгийн тайланд хийсэн аудит | 8 |
| 2.6. Санхүүгийн тайлангийн аудитыг гэрээгээр: | 8 |
| 2.7. Орон нутгийн Хурлын ээлжит сонгуулийн жилийн өмнөх тайлант жилийн хугацаанд тухайн намд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг хянан, баталгаажуулах аудит | 9 |
| 2.8. Төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, төсөл хөтөлбөр, сангийн 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн завсрын аудит | 9 |
| 2.9. Санхүүгийн тайлангийн аудитаар хийгдсэн шинэлэг ажлын талаар: | 9 |
| БҮЛЭГ-2 ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ | Error! Bookmark not defined. |
| 3.1. Улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт хийсэн гүйцэтгэлийн аудит | 10 |
| 3.2. Өвөрхангай аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит | 11 |
| 3.3. Сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд хийсэн аудит | 11 |
| 3.4. “Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсрол олгож буй өнөөгийн байдал, үр дүн”-д нэгдсэн удирдамжаар хийж буй гүйцэтгэлийн аудит | 11 |
| БҮЛЭГ-3 НИЙЦЛИЙН АУДИТ | Error! Bookmark not defined. |
| 4.1. Өвөрхангай аймагт 2019 оны шилэн дансны хуулийн хэрэгжилтэд нэгдсэн удирдамжаар хийсэн нийцлийн аудит | 12 |
| 4.2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тойрогт нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоох аудит | 13 |
| 4.3. Орон нутгийн ээлжит сонгуульд оролцохоо илэрхийлж бүртгүүлсэн улс төрийн нам, намуудын сонгуулийн эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөр, эдийн засгийн тооцоо судалгаанд дүгнэлт гаргах аудит | 13 |
| 4.4. Аймаг, сумын ИТХ-ын хуралд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн зардлын тайланг хянаж, олон нийтэд мэдээлэх аудит | 13 |
| 4.5. ОНХС-ийн 2019 оны хөрөнгийн зарцуулалтад хийсэн аудит | 13 |
| 4.6. Аймаг, сумын сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын санхүүжилт, түүний гүйцэтгэлд хийсэн аудит | 14 |
| БҮЛЭГ-4 ӨӨРИЙН САНААЧИЛГААР ХИЙСЭН АУДИТ | 15 |
| 5.1. Орон нутгийн төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийх гүйцэтгэлийн аудитаар: | 14 |



| | |
|---|-------------------------------------|
| 5.2. Арвайхээр цэцэрлэгжилт ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны үр дүнд хийх нийцлийн аудитаар: | 14 |
| 5.3. Баянтээг ХК-ийн 2019 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитаар: | 14 |
| 5.4. Өвөрхангай аймгийн орон нутгийн 2021 оны төсвийн төсөлд орлого нэмэгдүүлэх, зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар санал: | 15 |
| БҮЛЭГ-5 СУРГАЛТЫН ТАЛААР:..... | Error! Bookmark not defined. |
| БҮЛЭГ-6 БАЙГУУЛЛАГЫН ДОТООД АЖЛЫН ТАЛААР:..... | Error! Bookmark not defined. |
| БҮЛЭГ-7 АУДИТЫН МӨРӨӨР ХИЙСЭН АЖИЛ | Error! Bookmark not defined. |
| БҮЛЭГ-8 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ: | Error! Bookmark not defined. |
| БҮЛЭГ-9 ДҮГНЭЛТ, САНАЛ | 16 |



ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

| | |
|-----------------|--|
| ААН | Аж ахуй нэгж |
| ГАГ | Гүйцэтгэлийн аудитын газар |
| ЕБС | Ерөнхий боловсролын сургууль |
| ЗДТГ | Засаг даргын тамгын газар |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| МУЕА | Монгол улсын ерөнхий аудитор |
| НАГ | Нийцлийн аудитын газар |
| НББ | Нягтлан бодох бүртгэл |
| НДС | Нийгмийн даатгалын сан |
| ОННТ | Орон нутгийн нэгдсэн тайлан |
| ОНӨААН | Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| СТАУС | Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын систем |
| СУГ | Стратеги удирдлагын газар |
| ТАБ | Төрийн аудитын байгууллага |
| ТАТХ | Төрийн аудитын тухай хууль |
| ТАХ | Төсөл, арга хэмжээ |
| ТГ | Тамгын газар |
| ТЕЗ | Төсвийн ерөнхийлөн захирагч |
| ТТЗ | Төсвийн төвлөрүүлэн захирагч |
| ТЭЗҮ | Техник, эдийн засгийн үндэслэл |
| УИХ | Улсын Их Хурал |
| УСНББОУС | Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт |
| УТХО | Улсын төсвийн хөрөнгө оруулалт |
| ҮАГ | Үндэсний аудитын газар |
| ХАК | Хувийн аудитын компани |
| ХДТ | Хөгжимт драмын театр |



| | |
|------------|--|
| <i>ХК</i> | <i>Хувьцаат компани</i> |
| <i>ХХК</i> | <i>Хувьцаат хязгаарлагдмал компани</i> |
| <i>ТАБ</i> | <i>Төрийн аудитын байгууллага</i> |

БҮЛЭГ-1

УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

Төрийн аудитын тухай хуулийн дагуу УИХ-ын Төсвийн байнгын хорооноос баталсан аудит хийх сэдэв, ҮАГ-ын 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, тус газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хүрээнд хийгдэх санхүүгийн болон гүйцэтгэл, нийцлийн аудитыг төлөвлөсөн хугацаанд хийж, дүгнэлт, зөвлөмж гарган хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлж ажиллав.

Төрийн аудитын байгууллагын хэмжээнд 2020 оныг “Төрийн аудитын байгууллагын эрх зүйн орчин, стандартын шинэтгэл”-ийн жил болгосонтой холбогдуулан тус газраас

- ✚ “Төрийн аудитын байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний журам”-ын төсөл,
- ✚ “Төрийн аудитын байгууллагын дотоод аудитын журам”-ын төсөл.
- ✚ Төрийн аудитын үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах стратеги төлөвлөгөөний төсөл.
- ✚ Төрийн аудитын байгууллагын 2020-2025 онд мэдээллийн технологийн чиглэлээр хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөний төсөл.
- ✚ “Санхүүгийн тайланд аудит хийх хуулийн этгээдийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах журам”-ын төсөл.
- ✚ “Нөлөөллийн мэдүүлэг” журмын төсөл,
- ✚ “Төрийн аудитын байгууллагаас шинжээч сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах” журмын төсөл,
- ✚ “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын төсөл.
- ✚ “Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл”, “Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын төсөл.
- ✚ Шилэн дансны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд ажилтнуудаас санал авч нэгтгэн ҮАГ-ын холбогдох газруудад хүргүүлж ажилласан.

Аудитын үйл ажиллагааг олон улсын стандарт, хууль, журам, заавруудын хүрээнд явуулж ирэв.

Энэ онд Монгол улсын Ерөнхий аудиторын тушаалаар баталсан бүтэц, 12 орон тоотойгоор ажиллаж, багийн зохион байгуулалтыг санхүүгийн аудитын албаны 3, гүйцэтгэлийн аудитын албаны 3, нийцлийн аудитын албаны 3 аудитор байхаар зохион байгуулж ажилласан.

Удирдлагын зөвлөлийн хурлыг 10 удаа хийж тухай бүр асуудлыг шийдвэрлэн ажилласан.

Тэргүүлэх аудитор нь аудитын баг, ажилтнуудын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж, улирал бүр гүйцэтгэлийн төлөвлөгөөг дүгнэж, хагас бүтэн жилийн тайлан, статистик мэдээг журмын дагуу хугацаанд нь гаргаж ҮАГ-т хүргүүлэв.



Аймгийн Прокурорын газартай “Хамтын ажиллагааны санамж бичиг”-т гарын үсэг зурж, хамтран ажиллаж байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар хамтарч ажилласан гэрээт ажилтан, ХАК-тай байгуулсан гэрээг 92.0-93.0 хувийн гүйцэтгэлтэйгээр дүгнэсэн.

Монгол Улсын Ерөнхий Аудиторын баталсан төлөвлөгөө, нэгдсэн удирдамжаар гүйцэтгэлийн 4 сэдвээр, нийцлийн 2 сэдвээр, УИХ болон орон нутгийн ИТХ-ын захиалга болон өөрийн санаачилгаар 8 сэдвээр, санхүүгийн тайлангийн аудитаар 271, бүгд 285 тайланд аудитыг гүйцэтгэлээ.

2020 онд 405 төрлийн 68785.3 сая төгрөгийн зөрчил илүүлснээс 101 төрлийн 2445.9 сая төгрөгийн зөрчлийг аудитын явцад залруулсан.

Нийт акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /сая төгрөгөөр/



Энэ онд 189 төрлийн 7083.0 сая төгрөгийн зөвлөмж өгснөөс 167 төрлийн 6910.4 сая төгрөгийн зөвлөмжийг хэрэгжүүлэн биелэлт 97.6 хувь, 89 төрлийн 59164.3 сая төгрөгийн албан шаардлага өгч 78 төрлийн 58439.7 сая төгрөгийн албан шаардлагыг биелүүлэн хэрэгжилт 98.8 хувь, 12 төрлийн 92.1 сая төгрөгийн төлбөрийн актаас 10 төрлийн 18.8 сая төгрөгийг барагдуулж, биелэлт 20.4 хувьтай байна. Актын дутуу 72.8 сая төгрөгийг барагдуулахаар аймгийн Прокурорын байгууллагад холбогдох нотлох баримтыг хүргүүлээд байна.

Аудитаар байгууллага, аж ахуйн нэгжид үр өгөөж тооцсоноор 27 төрлийн 6777.7 сая төгрөгийн аудитын үр өгөөжийг бүртгэн тухайн байгууллагуудын удирдлагаар хүлээн зөвшөөрүүлэн, төсвөөс авсан санхүүжилтийн 1 төгрөгийн хариуд 12 төгрөг 49 мөнгөний үр өгөөж бий болгосон байна.



БҮЛЭГ-2


САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

МУЕА-ын 2019 оны А/60 дугаар тушаалаар: Санхүүгийн тайлангийн аудит хийгдвэл зохих 271 байгууллага, аж ахуйн нэгжээс Санал дүгнэлт гаргах-92, Үе шатны ажлыг хэсэгчлэн хийх-74, Итгэл үзүүлэх-41, Гэрээгээр аудит хийлгэх-64 байгууллага, аж ахуйн нэгжийг тус тус баталсан.

Санхүүгийн тайлангийн аудитаар ОННТайлан-1, 19 сумын ТТЗ-ын нэгтгэсэн тайлан, 42 тусгай сан, 199 төсвийн шууд захирагч, 10 аж ахуй нэгж, нийтдээ 271 байгууллагын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хамруулснаас 41 төсвийн шууд захирагч, сангуудад итгэл үзүүлж, 75 байгууллагын санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, 155 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийж дүгнэлт гаргасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар 147 байгууллагад зөрчилгүй, 8 байгууллагад “Хязгаарлалттай” дүгнэлтийг өгч, “Сөрөг” болон “Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан” дүгнэлт гараагүй байна.

График-1 Санхүүгийн тайлангийн аудитын нийт илрүүлэлт



Аудитаар нийт 308 төрлийн 4283.3 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлэн 101 төрлийн 2445.9 сая төгрөгийн алдаа зөрчлийг аудитын явцад залруулж, 9 төрлийн 6.3 сая төгрөгийн акт тавьж, 8 төрлийн 5.8 сая төгрөгийн актыг барагдуулан биелэлт 92.1 хувь, 54 төрлийн 608.2 сая төгрөгийн албан шаардлага өгснөөс 53 төрлийн 599.5 сая төгрөгийн албан шаардлагыг хэрэгжүүлэн биелэлт 98.6 хувь, 130 төрлийн 1222.9 сая төгрөгийн зөвлөмж өгснөөс 126 төрлийн 1050.3 сая төгрөгийн зөвлөмжийг хэрэгжүүлэн биелэлт 96.9 хувьтай байна.

Үүнээс гэрээгээр гүйцэтгэсэн хувийн аудитын компаниуд орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр 6.0 сая төгрөгийн төлбөрийн акт, 27.6 сая төгрөгийн албан шаардлага, 48 төрлийн 235.6 сая төгрөгийн зөвлөмж хүргүүлсэн байна.



Санхүүгийн тайлангийн аудитаар 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар байгууллага, аж ахуйн нэгжид үр өгөөж тооцсоноор 6.3 сая төгрөгийн аудитын үр өгөөжийг бүртгэн тухайн байгууллагуудын удирдлагаар хүлээн зөвшөөрүүлэв.

Нийт илрүүлсэн 4283.3 сая төгрөгийн зөрчлөөс нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 2674.2 сая төгрөг, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 110.3 сая төгрөг, дотоод хяналт хариуцлагатай холбоотой 709.4 сая төгрөг, орлого бүрдүүлэлт, төсвийн гүйцэтгэлтэй холбоотой 221.7 сая төгрөг, арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөг сайжруулахтай холбоотой 124.6 сая төгрөг, худалдан авалттай холбоотой 358.0 сая төгрөг, зориулалт бус зарцуулсан 54.0 сая төгрөгийн зөрчил илэрчээ.

Өгсөн зөвлөмжийн 8 нь арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөг сайжруулах, 41 нь бүртгэл тайлагналтай холбогдолтой, 17 нь хууль тогтоомжийн хэрэгжилттэй, 39 нь дотоод хяналт сайжруулах, 9 нь худалдан авалт, төсвийн төлөвлөлт гүйцэтгэлтэй холбоотой зөвлөмжүүд өгөгдсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын бодлого чиглэлийн дагуу 8 асуудлын хүрээнд хийсэн танилцуулга дүгнэлтээс үзэхэд: Төсөвт байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн боловсруулалт, шинэчлэлт, мөрдөлт учир дутагдалтай, төсөвт байгууллагуудын санхүүгийн программууд ойр ойрхон солигдож, ашиглагдаагүй бүртгэлтэй биет бус хөрөнгүүд ихэссэн байна.

Программын ашиглалт ч сайнгүй байна. Тухайлбал: интернэтийн орчин хязгаарлагдмал сум орон нутгийн байгууллагуудад ашиглахад хүндрэлтэй, УСНББОУС, тухайн байгууллагын НББ-ийн бодлогын баримт бичигтэй зарим талаараа уялдахгүй, Сангийн яам, Татвар, Нийгмийн даатгалын байгууллагуудтай цахимаар мэдээлэл солилцох, тайлангаа хөрвүүлэх зэрэг наад захын хэрэгцээ шаардлагыг хангахгүй программууд хэрэглэгдсээр байна.

2.1. Орон нутгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгдсэн тайланд хийсэн аудит

Нэгдсэн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлтийг өгсөн бөгөөд тайланд эрхлэх асуудлын хүрээний харьяа 165 төсвийн байгууллага, 5 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 40 тусгай сан, 19 төрийн сан 5 данс нийт 234 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 191 байгууллага аудитад хамрагдаж, 36 байгууллагад итгэл үзүүлсэн, 3 байгууллага, 4 данс аудитад хамрагдаагүй байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас 73 байгууллагыг түүвэрт хамруулж, 118 байгууллагад дүгнэлт гаргаснаас “Зөрчилгүй” 112 байгууллага, аж ахуйн нэгж, “Хязгаарлалттай” 6 байгууллага, аж ахуйн нэгж байна.

“Хязгаарлалттай” санал дүгнэлтийг Сант сумын Төрийн сан, Баруунбаян-Улаан сумын Төрийн сан, Нарийнтээл сумын ЕБС, Баруунбаян-Улаан сумын ЕБС, Баруунбаян-Улаан сумын ЗДТГазар, Хужирт-Эрдэс баялаг ОНӨААТҮГ-т тус тус өгчээ.

Өвөрхангай аймгийн ТЕЗ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар харьяа байгууллага, аж ахуйн нэгжүүдэд нийт 3190.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 2144.0 сая төгрөгийн алдааг залруулж, 1.6 сая төгрөгийн зөрчилд 7 төлбөрийн акт тогтоож, 474.3 сая төгрөгийн зөрчилд 44 албан шаардлага, 12 албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлж, 570.7 сая төгрөгийн алдаа, зөрчилд 104 зөвлөмж өгсөн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн тайланд 40.8 сая төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмжийг өгсөн.

2.2. Төсвийн төвлөрүүлэн захирагчдын санхүүгийн тайланд хийсэн аудит



Аймгийн 19 сумын санхүүгийн тайланд хийсэн аудитаар 17 тайланд “Зөрчилгүй”, 2 тайланд “Хязгаарлалттай” дүгнэлтийг өгсөн. “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн Баруунбаян-Улаан, Сант сумдын Төрийн сангийн 4 албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлж, хэрэгжилтийг хангуулав.

Аудитаар нийт 1048.4 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлэн 985.6 сая төгрөгийн алдаа зөрчлийг аудитын явцад залруулж, 62.8 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага өгсөн.

2.3. Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайланд хийсэн аудит

Нийт 199 байгууллагын санхүүгийн тайланд хийсэн аудитаар: 22 байгууллагад “Итгэл” үзүүлж, 177 санхүүгийн тайланд аудит хийснээс 55 байгууллагын санхүүгийн тайланг үе шатны ажлыг хэсэгчлэн хийж, 122 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаснаас 118 байгууллагад “Зөрчилгүй” дүгнэлт, 4 байгууллагад “Хязгаарлалттай” дүгнэлтийг өгч, Сөрөг болон Дүгнэлт өгөхөөс татгалзсан дүгнэлт гараагүй байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн

- ✚ Баруунбаян-Улаан сумын ЗДТГазар, ЕБСургууль,
- ✚ Нарийнтээл сумын ЕБСургууль,
- ✚ Хархорин музей

дээрх 4 байгууллагын удирдлагад хариуцлага тооцуулахаар аймгийн Засаг даргад албан шаардлага хүргүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллав.

Тус аудитаар нийт 2438.2 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлэн 1258.6 сая төгрөгийн алдаа зөрчлийг аудитын явцад залруулж, 1.2 сая төгрөгийн акт, 371.6 сая төгрөгийн албан шаардлага, 806.8 сая төгрөгийн зөвлөмжийг өгсөн байна.

2.4. Засгийн газрын тусгай сангуудын санхүүгийн тайланд хийсэн аудит

Нийт 42 тусгай сангийн санхүүгийн тайлангаас Сум хөгжүүлэх 19 санд “Итгэл” үзүүлж, Тариалан эрхлэлтийг дэмжих сан, Халамжийн сан, Нийгмийн даатгалын сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан зэрэг 4 санд дүгнэлт гаргаж, Орон нутгийн хөгжлийн 19 сангийн 2019 оны санхүүгийн тайланд үе шатны ажлыг хэсэгчлэн хийсэн байна.

Аудитаар нийт 361.7 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлэн 49.7 сая төгрөгийн алдаа зөрчлийг аудитын явцад залруулж, 121.5 сая төгрөгийн албан шаардлага, 190.5 сая төгрөгийн зөвлөмжийг өгсөн.

2.5. Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуй нэгжийн санхүүгийн тайланд хийсэн аудит

Нийт 10 аж ахуйн нэгжүүдийн 2019 оны санхүүгийн тайланд хийх аудитыг орон нутагт байрлах 2 ХАК-тай гэрээ байгуулан 9 аж ахуйн нэгжид аудитыг гүйцэтгүүлсэн. Харин Бат-Өлзий сумын Тохжилт үйлчилгээ ОНӨААТҮГ нь үйл ажиллагаа явуулаагүйгээс аудит хийгдээгүй болно.

Аудитаар 247.5 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлэн 4.7 сая төгрөгийн алдаа зөрчлийг аудитын явцад залруулж, орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр 5.2 сая төгрөгийн төлбөрийн акт, 16.4 сая төгрөгийн албан шаардлага, 221.2 сая төгрөгийн зөвлөмж хүргүүлсэн байна.

2.6. Санхүүгийн тайлангийн аудитыг гэрээгээр:

Гэрээт 1 ажилтнаар төсвийн шууд захирагчийн үе шатны ажлыг хэсэгчлэн хийх 25 байгууллагад аудит хийлгэв.

- ✚ Дөлгөөнхайрхан-Уул аудит ХХК-тай 31 байгууллага, аж ахуйн нэгж,



✚ Б энд С аудит ХХК-тай 32 байгууллага, аж ахуйн нэгж, нийтдээ 63 байгууллага, аж ахуйн нэгжид аудитыг хийлгүүлж, чанарын хяналтыг хэрэгжүүлж ажилласан.

Аудитаар: “ӨВ ЭКО МИЙТ” ОНӨААН, “Хужирт-Эрдэс баялаг” ОНӨААН гэсэн 2 аж ахуйн нэгж, байгууллагад “Хязгаарлалттай” дүгнэлтийг өгч, хариуцлага тооцуулахаар аймгийн Засаг даргад албан шаардлага хүргүүлж, хэрэгжилтийг хангуулсан.

Аудитын компаниудын гэрээт ажлын хөлсөнд 42.9 сая төгрөгийн аудитын төлбөрийн гэрээ хийж байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан гүйцэтгэлийг хянан санхүүжүүлсэн.

Хараат бус аудитын хуулийн этгээдийн хийсэн санхүүгийн тайлангийн аудитын ажлын гүйцэтгэлийг үнэлэх, тайлагнах заавар, аргачлалын дагуу Дөлгөөнхайрхан-Уул аудит ХХК, Б энд С аудит ХХК-ийн хийсэн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын ажлын гүйцэтгэлд үнэлгээ хийж, байгуулсан гэрээг 92.0-93.0 хувийн гүйцэтгэлтэйгээр дүгнэв.

Санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэсэн байгууллага, аж ахуйн нэгж, сангуудын үе шатны ажлуудыг СТАУС программд 100.0 хувь оруулсан.

СТАУС-д 2021 онд аудит явуулах байгууллагын мэдээлэл, нэмэгдсэн хасагдсан байгууллага, сангуудын мэдээллийг шивж оруулав. Санхүүгийн 2020 оны тайланд аудит хийх байгууллагын жагсаалт, аудитын төрлийг тогтоон саналаа ҮАГ-ын СУГ-т хүргүүлэн, МУЕА-ын тушаалаар баталгаажуулав.

2.7. Орон нутгийн Хурлын ээлжит сонгуулийн жилийн өмнөх тайлант жилийн хугацаанд тухайн намд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг хянан, баталгаажуулах аудит

Орон нутгийн Хурлын ээлжит сонгуулийн жилийн өмнөх тайлант жилийн хугацаанд тухайн намд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг хянаж баталгаажуулан дүгнэлтийг аймгийн Сонгуулийн хороо болон нэр бүхий 9 намуудад хүргүүлэв.

2.8. Төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, төсөл хөтөлбөр, сангийн 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн завсрын аудит

Хуваарийн дагуу Аймгийн ЗДТГазар, ХДТеатр, Цагдаагийн газар, Хархорин сумын нэгдсэн эмнэлэг, Хархорин-Ус суваг ОНӨААТҮГ, Политехник коллеж, Хархорин музей, Баруунбаян-Улаан сумын ЗДТГ, Арвайхээр сумын 4-р сургууль, Уянга сумын ЗДТГ, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн алба, Хужирт сумын ЭМТөв, Нарийнтээл сумын ЕБС, БОЭТөв, НДСан, Онцгой байдлын алба, Онги-Ус суваг ОНӨААТҮГ зэрэг 18 байгууллага, аж ахуйн нэгжүүдэд завсрын аудитыг гүйцэтгэлээ.

2.9. Санхүүгийн тайлангийн аудитаар хийгдсэн шинэлэг ажлын талаар:

1. Санхүүгийн тайлангийн аудитаар хугацаа хэмнэх, ажлаа хөнгөвчлөх үүднээс ашиглагдахгүй байгаа компьютерын дэлгэцүүдийг холбож нэг дэлгэцээр СТАУС программ дээр ажиллах, нөгөө дэлгэцээр ажлын баримт дээр ажиллах боломжийг бүрдүүлсэн.

2. Аймгийн хэмжээний бүх төсөвт болон төрийн өмчийн аж ахуй нэгжүүдийн удирдлагын мэдээллүүд, утасны жагсаалтыг шинэчлэн байгууллагын ажилтнуудад сүлжээгээр хүргүүлж, холбогдох ажилтнуудтай холбогдож цаг алдахгүй байх боломжийг бүрдүүлсэн.

БҮЛЭГ-3

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ

Гүйцэтгэлийн аудитаар ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар 4 сэдвийн, аймгийн ИТХ-ын хүсэлт, захиалга болон өөрийн санаачилгаар 3 сэдвийн, нийтдээ 7 сэдвийн хүрээнд аудит хийж, давхардсан тоогоор 159 байгууллага, сумдыг хамруулан 2 төрлийн 83.5 сая төгрөгийн акт өгснөөс 1 төрлийн 10.7 сая төгрөгийг хэрэгжүүлж, биелэлт 12.8 хувьтай, 12 төрлийн 4491.3 сая төгрөгийн албан шаардлага өгснөөс 6 төрлийн 3998.6 сая төгрөгийн албан шаардлагыг барагдуулж, биелэлт 89.0 хувь, 38 төрлийн буюу 5290.0 сая төгрөгийн зөвлөмж өгсний 26 зөвлөмж буюу 5290.0 сая төгрөгийг хэрэгжүүлж, биелэлт 100.0 хувьтай хэрэгжсэн байна.

Тус аудитаар 16 төрлийн 5500.8 сая төгрөгийн үр өгөөж хүлээн зөвшөөрүүлсэн.

3.1. Улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт хийсэн гүйцэтгэлийн аудит

Тус аудитаар “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын гэрээний хэрэгжилтэд тавих хяналт сайжирсан ч, үр ашигтай төлөвлөх тогтолцоо бүрдээгүй, гүйцэтгээгүй ажилд санхүүжилт олгосон байна” гэсэн ерөнхий дүгнэлтийг өгөв.

Өвөрхангай аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн 123 төсөл, арга хэмжээг тайлант онд багтаан хэрэгжүүлэхээр гэрээ хийснээс 57.7 хувь нь гэрээт хугацаандаа хэрэгжиж, 36.6 хувь нь гэрээний хугацааг 1-124 хоног хэтрүүлж ашиглалтад хүлээлгэж өгсөн, 5.7 хувь нь гэрээний үүргээ биелүүлээгүй ажлын гүйцэтгэл 41-75 хувьтай байна.

График-2 УТХО-р 2019 онд хэрэгжих төсөл, арга хэмжээ



Аудитаар улсын төсвийн хөрөнгө оруулалтыг нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөх ажил хангалтгүй, төсөл арга хэмжээг үр ашигтай төлөвлөх тогтолцоо бүрдээгүй, зарим ажилд гүйцэтгэлээс илүү санхүүжилт олгосон, үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгчид хариуцлага тооцоогүй, хөрөнгө оруулалтын тухайн жилд хүрэх зорилт, үр дүнг тооцоогүй, зарим хөрөнгийг бүрэн ашиглахгүй байгаа зөрчлүүд гарсан байна.

Аймаг, орон нутгаас гаргасан зарим саналыг харгалзалгүйгээр улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталж байгаа нь барилга, байгууламж, их засварын зураг, төсвийг улсын төсөв батлагдахаас өмнө бус батлагдсаны дараа эх үүсвэрт нь тохируулан хийлгэх үндэслэл болж байна.



Жил бүр техник, эдийн засгийн үндэслэл, зураг, төсөв хийгдээгүй төсөл, арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд суулгаж, үндэслэл тооцоогүй санхүүжилтийн эх үүсвэр батлах асуудал гаргасаар байна. Энэ нь хөрөнгө санхүүжилтийг хийгдэх ажлаас хэт өндрөөр төлөвлөж, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, эсвэл хөрөнгө мөнгө дутагдсанаас барилгын чанар, норм, нормативыг хангахгүй барилга угсралт, их засварын ажлууд хийгдэх нөхцөлийг бүрдүүлж байгаад онцгой анхааран холбогдох хууль, журмыг хэрэгжүүлж ажиллах шаардлага байна.

Тус аудитаар 80.2 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 3652.1 сая төгрөгийн 4 албан шаардлага бичиж, холбогдох албан тушаалтнуудад 8 зөвлөмж өгч, 3732.3 сая төгрөгийн үр өгөөж тооцов.

3.2. Өвөрхангай аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

“Өвөрхангай аймгийн төсвийн 2019 оны орлого зарлагын төлөвлөлт, гүйцэтгэл хууль, эрх зүйн хүрээнд бүрэн хэрэгжиж, төсвийн гүйцэтгэлд тавих хяналт үр дүнгээ өгсөн байна” гэсэн ерөнхий дүгнэлтийг өгөв.

Аймгийн төсөвт орох татварын болон татварын бус орлогыг 9962.5 сая төгрөгөөр төлөвлөж 11089.0 сая төгрөг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөний биелэлт 111.3 хувийн биелэлттэй.

Сумын төсөвт орох татварын орлогоор 3884.9 сая төгрөг оруулахаас гүйцэтгэлээр 5424.9 сая төгрөг оруулж 139.6 хувийн биелэлттэй байна.

Орон нутгийн төсөвт орсон нийт татварын орлогын 68.4 хувийг аймгийн төсөвт, 31.6 хувийг сумын төсөвт оруулсан байна. Аудитаар зөрчил илрээгүй байна.

3.3. Сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд хийсэн аудит

Аудитаар “Улсын их хурлын 2020 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдуулан улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын төлөвлөлт, зарцуулалт үр дүнтэй байна” гэж эерэг дүгнэлтийг өгч тайланг УАГ-ын ГАГ-т болон аймгийн Сонгуулийн хороонд хүргүүлсэн. Аудитаар зөрчил илрээгүй байна.

3.4. “Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсрол олгож буй өнөөгийн байдал, үр дүн”-д нэгдсэн удирдамжаар хийж буй гүйцэтгэлийн аудит

Аудитаар “Ерөнхий боловсролын үйл ажиллагаанд тавих хяналтын хэрэгжилт үр дүнгүй байна” гэсэн ерөнхий дүгнэлтийг өгөв.

Аудитаар 3.7 сая төгрөгийн 1 акт, 3 албан шаардлага, 12 зөвлөмж өгч, 19.8 сая төгрөгт үр өгөөж тооцсон.

Сүүлийн 4 жилийн хугацаанд сургалтын “Цөм хөтөлбөр” батлагдан мөрдөгдөж байх хугацаанд Боловсролын тухай, Бага, дунд боловсролын тухай хууль, дүрэм, журмууд олон удаа өөрчлөгдсөн нь сургууль багш нарын үйл ажиллагааны тогтвортой байдлыг алдагдуулахад хүргэж, анги танхим дахь хичээлийн үр өгөөжийг бууруулж байна.

Чанарын үнэлгээгээр нийт сурагчдын дундаж улсын дунджаас дээгүүр дүгнэгдсэн байна. Сургалтын менежер нь багш нарын хичээлд суух хуваарь гарган багшийн заах арга зүйд хяналт тавьж ажиллаж байгаа боловч сургалтын хөтөлбөрт тавих хяналт дутагдалтай байна. Олон нийтийн зүгээс тавих хяналт, үүрэг оролцоо хангалтгүй байна.

Тус аудитад: Сурагчдын чанарын үнэлгээний мэдээллийг Google drive программ ашиглан дүгнэж нэгтгэсэн.

Аймгийн Засаг даргын дэргэдэх БСУГазарт ашиглагдаж байгаа Цахим кампус сургалтын программаас нийт багш нарын мэдлэг чадварыг дээшлүүлэх, чадавхжуулах



сургалтыг онлайнаар зохион байгуулж, сурагчдаас авах шалгалтын нэгдсэн сангийн дэлгэрэнгүй мэдээлэлд анализ дүгнэлт хийн аудитад ашигласан.

Бүх нийтийн ерөнхий боловсрол олгож буй өнөөгийн байдал, үр дүнд аудит хийснээр аймгийн ерөнхий боловсролын байгууллагуудын өөрийн үйл ажиллагаанд тавих дотоодын хяналт сайжирч, улмаар боловсролын чанарт ахиц дэвшил гарахад түлхэц болсноороо үр нөлөөтэй боллоо.

БҮЛЭГ-4

НИЙЦЛИЙН АУДИТ

Нийцлийн аудитаар УАГ-ын нэгдсэн удирдамжаар 2 сэдэв, УИХ, аймгийн ИТХ болон өөрсдийн санаачилгаар 5 сэдэв, нийтдээ 7 сэдвийн хүрээнд аудит хийж, давхардсан тоогоор 245 байгууллага, сумдыг хамруулж, 1 төрлийн 2.3 сая төгрөгийн акт тавьснаас 1 төрлийн 2.3 сая төгрөгийн актыг барагдуулж, биелэлт 100.0 хувьтай, 23 төрлийн 54064.8 сая төгрөгийн албан шаардлага тавьснаас 19 төрлийн 53841.6 сая төгрөгийг барагдуулж, биелэлт 99.6 хувьтай, 21 төрлийн 570.1 сая төгрөгийн зөвлөмж өгснөөс 15 төрлийн 570.1 сая төгрөгийн зөвлөмж хэрэгжиж, биелэлт 100.0 хувьтай гарсан байна.

Тус аудитаар 2 төрлийн 1270.6 сая төгрөгийн үр өгөөж тооцож хүлээн зөвшөөрүүлсэн.

4.1. Өвөрхангай аймагт 2019 оны шилэн дансны хуулийн хэрэгжилтэд нэгдсэн удирдамжаар хийсэн нийцлийн аудит

Тус аудитаар “Шилэн дансны тухай хуулийн 3.1.1, 3.1.2-д заасан байгууллагууд хуулийг 96.0 хувьтай хэрэгжүүлж, аймгийн хэмжээнд хуулийн 6.9, 8.1 дэх заалтуудын хэрэгжилт хангалтгүй байна” гэсэн ерөнхий дүгнэлт өгсөн.

Аудитад хамрагдсан хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-3.1.3 дахь хэсэгт хамаарах 163 байгууллагыг сонгож аудитыг гүйцэтгэсэн.

Аудитаар мэдээллийг дутуу болон хугацаа хоцроон мэдээлэх, төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгчид шилэн дансны нэгдсэн цахим хуудаст бүрэн хамрагдаагүй, хуульд заасан мэдээллийг шилэн дансанд хангалтгүй мэдээлсэн, хуулийн 8 дугаар зүйлд заасан байгууллага, албан тушаалтнууд холбогдох хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн зөрчил гарсан байна.

Улс орон нутгийн төсөв, ОНХС-ийн хөрөнгийн санхүүжилтээр арван сая төгрөгөөс дээш үнийн дүнгээр 163 ажил үйлчилгээ гүйцэтгэсэн 104 ААНэгж байгууллагууд 52920.0 сая төгрөгийн мэдээллээ байршуулаагүй шилэн дансны цахим хуудсанд бүртгэлгүй байжээ.

Аймгийн хэмжээнд Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст нийт 240 байгууллага хамрагдахаас 238 байгууллага мэдээллээ байршуулж, Төрийн чиг үүргийг гүйцэтгэгч Лхагва баасан, Жаргалант ирээдүйн мөрөөдөл цэцэрлэгүүд шилэн дансны цахим хуудсанд бүртгэлгүй байна.

Аудитаар Аймгийн ИТХ-ын дарга, аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга, холбогдох сумдын Засаг дарга нарт хандсан 6 зөвлөмж, 8 албан шаардлага өгсөн.

Дээрх зөвлөмж, албан шаардлагыг 100 хувь хэрэгжүүлж ажилласнаар дараах үр дүн хүрсэн байна. Үүнд:

1.Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч Лхагва баасан, Жаргалант ирээдүйн мөрөөдөл цэцэрлэгүүд нь төсвөөс 62.6



сая төгрөгийн санхүүжилт авсан боловч шилэн дансны бие даасан цэс нээлгээгүй, мэдээллээ байршуулдаггүй байсныг тогтмол мэдээлж хэвшсэн.

2. 2019 онд Төсвөөс хөрөнгө оруулалтын санхүүжилт авсан 104 аж ахуйн нэгж, байгууллагууд 52920.0 сая төгрөгийн мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим системд мэдээлэх эрх нээлгээгүй, мэдээллийг бүрэн байршуулаагүй байсныг аж ахуйн нэгжүүд захиалагчтай гэрээ байгуулахдаа гэрээнд тусган ажиллаж байна.

4.2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тойрогт нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоох аудит

Аудитаар аймгийн ИТХ-ын сонгуулийн тойрогт нам, эвсэл, нэр дэвшигчийн зардлын дээд хэмжээг Дарга бөгөөд тэргүүлэх аудиторын 2020 оны 06 дугаар сарын 29-ний А/09 дугаар тушаалаар 305.0 сая төгрөгөөр, сумдын ИТХ-ын нам, эвсэл, нэр дэвшигчийн зардлын дээд хэмжээг 2020 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн А/08 тоот тушаалаар 309.0 сая төгрөгөөр тооцон тушаалаар баталгаажуулан нам эвсэл болон холбогдох байгууллагуудад хүргүүлж, байгууллагын болон аймгийн сайтад тавив.

4.3. Орон нутгийн ээлжит сонгуульд оролцохоо илэрхийлж бүртгүүлсэн улс төрийн нам, намуудын сонгуулийн эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөр, эдийн засгийн тооцоо судалгаанд дүгнэлт гаргах аудит

Аудитыг аймгийн хэмжээнд нийт 8 намын мөрийн хөтөлбөр, эдийн засгийн тооцоо судалгаанд дүгнэлт гаргасан. Аймгийн Монгол Ардын нам, МАХН, Ардчилсан намуудын мөрийн хөтөлбөр нь холбогдох хууль, тогтоомжид нийцээгүй дүгнэлт өгч дахин мөрийн хөтөлбөр, эдийн засгийн тооцоо судалгааг гаргуулж, нийцсэн дүгнэлтийг аймгийн Сонгуулийн хороо болон Намуудад хүргүүлэв.

4.4. Аймаг, сумын ИТХ-ын хуралд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн зардлын тайланг хянаж, олон нийтэд мэдээлэх аудит

Орон нутгийн сонгуулийн тухай хуулийн 57.2.5 д заасны дагуу нам эвслийн зардлын тайлан гаргах хүлээн авах нийтэд мэдээлэх, танилцуулахтай холбоотой журам маягтыг Тэргүүлэх аудитораар батлуулж, ХАК-уудад болон орон нутгийн намууд, нэр дэвшигчдэд хүргүүлж, аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд оролцсон 4 нам, 977 нэр дэвшигчийн зардлын тайланг хянаж, байгууллагын сайтаар олон нийтэд мэдээлсэн. Аудитаар аймгийн ЗДТГ-ын СТСХэлтэст нэг зөвлөмж өгч ажиллав.

4.5. ОНХС-ийн 2019 оны хөрөнгийн зарцуулалтад хийсэн аудит

Аудитаар “ОНХС-ийн хөрөнгийг хууль журамд заасны дагуу төлөвлөж, хуваарилан зарцуулсан боловч зарим ажил чанаргүй хийгдсэн байна” гэсэн дүгнэлтийг өгч аймаг, сумдын Засаг дарга нарт 5 зөвлөмж, 12 төрлийн 1071.2 сая төгрөгийн албан шаардлага өгч, 698.2 сая төгрөгийн үр өгөөж хүлээн зөвшөөрүүлсэн байна.

Аудитын үр дүнд хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах болон хөрөнгө орлогот аваагүй зөрчлүүд бүрэн арилсан байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажлууд орон нутгийн иргэдэд үр өгөөжөө өгч, иргэдийн ая тухтай амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлсэн олон ажлууд хийгдсэн байна. Тухайлбал:

Сум болгон камержуулалд хийгдсэнээр иргэдийн амгалан тайван байдал хангагдаж, хулгай дээрэм багассан. Бүх суманд цэцэрлэгт хүрээлэн байгуулагдаж хүүхэд багачуудын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, таатай орчин бүрджээ.

Аймгийн төв дээр усан спортын төв, кино театр байгуулагдсанаар иргэдийн чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, цаашид соёлын талаар авч хэрэгжүүлж байгаа томоохон арга хэмжээ болж, үр дүнгээ өгсөн ажлууд хийгдсэн байна.



4.6. Аймаг, сумын сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын санхүүжилт, түүний гүйцэтгэлд хийсэн аудит

“Аймаг, сумын ИТХ-ын 2020 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдуулан улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын төлөвлөлт, зарцуулалт үр дүнтэй хэрэгжсэн байна” гэсэн дүгнэлт өгсөн. Тус сонгуульд 557.6 сая төгрөгийг зарцуулсан ба аудитаар зөрчил илрээгүй байна.

БҮЛЭГ-5

ӨӨРИЙН САНААЧИЛГААР ХИЙСЭН АУДИТ

5.1. Орон нутгийн төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийх гүйцэтгэлийн аудитаар:

“Орон нутгийн төсвийн 2019 оны зарим хөрөнгө оруулалтын үр дүн хангалтгүй байна” гэсэн ерөнхий дүгнэлтийг өгөв.

Аудитаар 445.2 сая төгрөгийн албан шаардлага бичиж, 445.2 сая төгрөгийн үр өгөөж тооцож, 7 зөвлөмж өгсөн.

Орон нутгийн төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтад хийсэн аудитаар: Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 27.2 хувийг аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2019 онд аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тулгуурлан төлөвлөөгүй, хөрөнгө оруулалтын шинж чанартай бус төсөл, арга хэмжээг төлөвлөж батлуулсан, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилт үр дүн хангалтгүй байсан байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн аудитын үр дүнд:

Хөрөнгө оруулалтын ТАХ-ний хэрэгцээ шаардлагыг оновчтой тодорхойлж, ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолтыг хууль, журам, стандартын дагуу боловсруулж хэвшиж байна.

Хөрөнгө оруулалтын ТАХ-г хүлээн авахдаа тендерт шалгарсан болон гэрээнд заасан техникийн тодорхойлолт, үзүүлэлт, тоо хэмжээтэй тулган үзэж, зөрүүтэй тохиолдолд гүйцэтгэгчид буцааж шаардлага хангасан бараа, ажил, үйлчилгээг авч ажилласан.

5.2. Арвайхээр цэцэрлэгжилт ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны үр дүнд хийх нийцлийн аудитаар:

“Байгууллагын үйл ажиллагаа хэвийн явагдсан боловч дотоод хяналт хийгдээгүй, төлөөлөн удирдах зөвлөл хангалтгүй ажилласан байна” гэсэн ерөнхий дүгнэлтийг өгсөн.

Аудитаар 2.3 сая төгрөгийн акт, 11.0 сая төгрөгийн албан шаардлага өгч, 579.8 сая төгрөгийн зөвлөмж өгч, 582.1 сая төгрөгийн үр өгөөж тооцож хүлээн зөвшөөрүүлсэн.

Тус аудитаар 2019 онд Арвайхээр суманд нийтийн эзэмшлийн 2 га талбайд зүлэгжүүлэлтийн хөрс бэлтгэхэд олон наст ургамлын 176.0 сая төгрөгийн цэцэрлэгжүүлэлтийн ажил хийгдсэнээс 76.0 сая төгрөгийн тарилт ургалтгүй болсон байсныг нөхөн зүлэгжүүлэлт хийлгэсэн.

Үндсэн үйл ажиллагааны орлого 32.4 сая төгрөг, үндсэн бус үйл ажиллагааны орлого 7.0 сая төгрөгөөр баталсан боловч орлогын төрөл тус бүрээр баталж өгөөгүй орлого бүрэн төвлөрөөгүй байсан. Үүний дагуу зөвлөмж өгсний үр дүнд орлогын төлөвлөгөөг ТУЗ-өөрөө зардал тус бүрээр төлөвлөн батлуулж орлого бүрдсэн байна.

5.3. Баянтээг ХК-ийн 2019 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитаар:



“Баянтээг ХК нь 2019 онд хэрэглэгчдийг шаардлагатай хэмжээний нүүрсээр тасралтгүй хангасан ч үйл ажиллагааны төлөвлөлт хангалтгүй байна” гэсэн ерөнхий дүгнэлтийг өгөв.

Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг хуулийн дагуу оновчтой хэрэгжүүлсэн боловч уурхайн ажлын гол үндэс болох уулын ажлын төлөвлөлт нь үндэслэлгүй байгаагаас үйлдвэрлэлийн үйл ажиллагааг ТЭЗҮ-д тусгагдсанаас зөрүүтэй төлөвлөсөн, хөрс хуулалтын төлөвлөгөөг давуулан биелүүлсэн боловч зарим шугамуудад давхардуулан хуулсан, нүүрс олборлолтыг хуулсан талбайгаас хийгээгүй зэрэг технологийн зөрчил түгээмэл гарч байна. 2019 онд ТЭЗҮ, уулын ажлын төлөвлөгөөнд тусгагдаагүй шугамд хөрс хуулжээ. Мөн авлага барагдуулах талаар тодорхой ажил зохион байгуулаагүй, удирдлагын зардлыг үндэслэлтэй төлөвлөөгүй, түлш шатахууны зардлыг арвилан хэмнэлттэй зарцуулаагүй, хөрөнгийн тооллогын үр дүн хангалтгүй байна.

Аудитаар 3 албан шаардлага, 12 зөвлөмж өгч, 377.9 сая төгрөгт үр өгөөж тооцсон.

Аудитаар: Компанийн үйл ажиллагааг бодитоор дүгнэх үүднээс ажилчдаас санал асуулга авч нэгтгэсэн.

Баянтээг ХК-ийн 2019 оны үйл ажиллагааны үр дүнд гүйцэтгэлийн аудит хийснээр тус компани үйл ажиллагаагаа үндэслэлтэй төлөвлөж, уулын ажлын төлөвлөгөөг ТЭЗҮ-дээ нийцүүлэн боловсруулах болсон нь чухал ололт болсон. Мөн маркшейдерийн гаргасан тооцооллын алдааг аудитын явцад илрүүлэн аудиторчуудын зүгээс залруулга хийж ажилласан нь үр дүнтэй боллоо.

5.4. Өвөрхангай аймгийн орон нутгийн 2021 оны төсвийн төсөлд орлого нэмэгдүүлэх, зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар санал:

Орон нутгийн 2021 оны төсвийн төсөлд орлогыг 348.1 сая төгрөгөөр нэмэгдүүлэх, зарлагыг 1,345.8 сая төгрөгөөр бууруулах саналыг оруулж, аймгийн ИТХ-аас төсвийн зарлагыг 926.0 сая төгрөгөөр бууруулахаар хүлээн зөвшөөрч шийдвэртээ тусгасан байна.

БҮЛЭГ-6

СУРГАЛТЫН ТАЛААР:

ҮАГ-аас зохион байгуулсан “Төрийн аудитын байгууллагын удирдах ажилтны зөвлөгөөн”-д газрын дарга, тэргүүлэх аудитор Л.Ламаачин, Удирдлагын академиас зохион байгуулсан ахлах түшмэлийн 14 хоногийн 8 багц сургалтад ахлах аудитор П.Хорлоосүрэн, Б.Эрдэнэцэцэг нар, нягтлан бодогч, бичиг хэргийн ажилтан М.Болортуяа аймгийн СТСХэлтсээс зохион байгуулсан “Цалингийн нэгдсэн программ”-ын сургалт, Ахлах аудитор Б.Эрдэнэцэцэг, аудитор Ө.Ринчинмядаг, Р.Цэрэндолгор, Ц.Мөнхзаяа нар ММНБИ-ээс зохион байгуулсан 21 кредит цагийн Мэргэжлийн тасралтгүй хөгжлийн сургалтад тус тус хамрагдав.

Байгууллагын 2020 оны дотоод сургалтын төлөвлөгөө боловсруулан баталж, төлөвлөгөөний дагуу 3 сургалт хийж 15 хүн хамрагдан 10 цагийн сургалт хийсэн. Үүнд:

- ✚ Төрийн болон албаны нууцын тухай хууль, журам, “Мэдээллийн аюулгүй байдлыг хангах” чиглэлээр
- ✚ МУЕА-ын 2019 оны №А/60 дугаар “Санхүүгийн тайлангийн аудит хийх байгууллагын жагсаалт, аудит хийх хэлбэр батлах тухай” тушаал



- ✚ МУЕА-ын 2019 оны №А/87 дугаар тушаалаар “ТАБ-аас 2019-2020 онд санхүүгийн тайлангийн аудит хийх ерөнхий чиглэл”
- ✚ Санхүүгийн тайлангийн аудитаар илэрдэг нийтлэг зөрчил дутагдал, цаашид анхаарах асуудал
- ✚ Санхүүгийн тайлангийн аудитаар эрсдэлийг тодорхойлох зэрэг сэдвээр сургалт хийсэн.

Монгол улсын Ерөнхий аудитор Д.Занданбат тэргүүтэй ҮАГ-ын зарим удирдлага тус газрын үйл ажиллагаатай танилцаж, дараах сургалтыг хийсэн. Үүнд:

- ✚ Ерөнхий аудитор Д.Занданбат-Харилцаа, хандлагын талаар,
- ✚ СУГ-ын дарга Б.Бундхорол-Стратегийн бодлого, үйл ажиллагаа болон ТАТХуулийн шинэчилсэн найруулгын талаар,
- ✚ Чанарын баталгаажуулалтын газрын дарга Я.Самбууням-Чанарын баталгаажуулалтаар хийгдсэн ажил, цаашид анхаарах асуудал, ОН-ын ТЕЗ-ийн тайлангийн нэгтгэлээр нийтлэг гарсан алдаа зөрчлийн талаар,
- ✚ СУГ-ын аудитын менежер Х.Баярмаа – Орон нутгийн сонгуулийн хуульд заасан аудит болон Үр өгөөжийн асуудлаар тус тус сургалт зохион байгуулав.

Төрийн аудитын байгууллагын ажилтны мөрдөх “Ёс зүйн дүрэм”, “Нөлөөллийн мэдүүлэг хөтлөх журам”-ын төслийн талаар ҮАГ-аас зохион байгуулсан цахим сургалтад ажилтнууд бүрэн хамрагдав.

“Төрийн аудитын байгууллагын ёс зүйн дүрэм” болон Удирдах ажилтны зөвлөгөөний материалыг ажилтнуудад дотоод сүлжээгээр хүргүүлэн судлуулав.

Ажилтнууд Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулгын дагуу бэлтгэсэн “Хуулийн хэрэглээ” хичээлийн цахим сургалтад оролцож, шалгалтыг амжилттай өгөв.

БҮЛЭГ-7

БАЙГУУЛЛАГЫН ДОТООД АЖЛЫН ТАЛААР:

Тайлангийн хугацаанд тус газрын дарга бөгөөд тэргүүлэх аудиторовын А тушаал 19, Б тушаал 9 гаргаж, явсан бичиг 523, ирсэн бичиг 212 бүртгэж, хариутай 169 албан бичгийг хугацаанд шийдвэрлэсэн байна. Мөн ҮАГ-аас дотоод сүлжээгээр танилцуулагдсан мэдээ, мэдээлэл, сургалтад тогтмол оролцон үүрэг даалгаврын биелэлтийг тухай бүр гаргаж ажиллав.

ҮАГ-аас санал авахаар ирүүлсэн нэр бүхий 9 журмын болон төлөвлөгөөний төсөлд санал өгсний зэрэгцээ “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт аудит хийж, дүгнэлт гаргах аргачлал”, “Нам, эвслээс ирүүлсэн хандивын тайланг хянан баталгаажуулж, дүгнэлт гаргах заавар”, “Нам, эвсэл болон нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоох аргачлал”-ын төсөлд тус тус саналыг гаргаж, ҮАГ-ын ТГ, СУГ, НАГ-т тус тус хүргүүлсэн байна.


Сар бүрийн үйл ажиллагааны тайлан мэдээ, хүний нөөцийн мэдээ судалгаа, үүрэг даалгаврын биелэлт, аудиттай холбоотой судалгаа, мэдээлэл, файлыг гарган ҮАГ-ын холбогдох газарт, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, тайлан, статистик мэдээг нэгтгэн Стратеги удирдлагын газар, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт улирал, хагас, бүтэн жилээр гарган хугацаанд нь хүргүүлээ.

Өөрийн байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй болгож мэдээллийн самбарт үндсэн ажлын чиг үүрэг хийсэн ажлын товч тайлан, төсвийн зарцуулалтын мэдээ,



шалгагдагч байгууллагын талаарх мэдээлэл, санхүүгийн тайлангийн аудит хийх хуваарь зэрэг холбогдох мэдээллийг тухай бүр шинэчлэн тавьж ил тод байдлыг хангаж ажиллав. Байгууллагаа сурталчлах самбарыг “Байгууллагын ялгамж чанар, дизайны загвар ашиглах хөтөч”-ийн дагуу шинээр хийж, Нутгийн удирдлагын ордны 4-н давхарт байрлуулав.

Зураг-1 Байгууллагын
мэдээллийн самбар



Байгууллагын веб сайт <http://www.audit.mn/> -д тухайн онд хийсэн аудитын тайлан, акт, албан шаардлага зөвлөмжийн хэрэгжилт, аудитын шалгалтын дүнгийн талаарх товч тайлан, цаг үеийн 9 мэдээллийг тавьсан байна. Үүнд:

- ✚ “Аймаг дахь ТАГ-ын 2019 оны үйл ажиллагааны тайлан”,
- ✚ “Аудитын газрын аудиторуд, гэрээт ажилтан, гэрээгээр аудит хийхээр гэрээ байгуулсан хувийн аудитын компаниудын аудиторудад 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар анхаарах асуудал, ЯАГ-аас өгсөн Ерөнхий чиглэл, зөвлөмж, аргачлал заавар”-ын талаар сургалт.
- ✚ “Орон нутгийн төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”, “Арвайхээр цэцэрлэгжилт ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн болон нийцлийн аудитын гүйцэтгэлийн шатны ажлууд хийгдэж буй.
- ✚ “Нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээ”-г тогтоосон
- ✚ “Нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөр” болон “Орон нутгийн Хурлын ээлжит сонгуулийн жилийн өмнөх тайлант жилийн хугацаанд тухайн намд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандив”-т аудит хийгдсэн талаар
- ✚ “ОНХС-ийн 2019 оны хөрөнгийн зарцуулалт” болон “Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсрол олгож буй өнөөгийн байдал, үр дүн”-д хийх аудитын гүйцэтгэлийн шатны ажлууд хийгдэж байгаа.
- ✚ “Өвөрхангай аймгийн болон сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцож буй нам, эвслийн хандивын тайлан, хандивын тайлангийн дүгнэлт, мөрийн хөтөлбөр болон мөрийн хөтөлбөрт хийсэн дүгнэлт”, “Орон нутгийн сонгуулийн тайлан гаргах, хяналт тавих журам болон сонгуульд оролцсон намуудад тайлан мэдээний загвар, өгсөн чиглэл”
- ✚ “Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсрол олгож буй өнөөгийн байдал, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудит, “ОНХС-ийн 2019 оны хөрөнгийн зарцуулалт”-д хийсэн нийцлийн



аудитын тайланг баталгаажуулан холбогдох газруудад хүргүүлсэн болон Баянтээг ХК-ын 2019 оны үйл ажиллагааны үр дүнд гүйцэтгэлийн аудитыг гүйцэтгэж байгаа зэрэг мэдээллийг байршуулсан. Мөн санхүүгийн тайлангийн аудитын тайлан дүгнэлтийг сайтад байршуулж байна.

Авлигаас урьдчилан сэргийлэх 2020 оны ажлын төлөвлөгөө боловсруулан баталж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Ажилтнуудаас хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг цахимаар болон цаасаар хуулийн хугацаанд хүлээн авч баталгаажуулан, аудит хийх тухай бүр ашиг сонирхолгүйн зөрчилгүй мэдэгдлийг гаргуулан ажиллав.

Төрийн болон албаны нууц хамгаалах журмын дагуу нууц хамгаалах, тээвэрлэх, тээгчтэй холбоотой 12 бүртгэлийн дэвтрийг хөтөлж, ҮАГ-аас ирүүлсэн нууцтай холбоотой 7 ширхэг тамга тэмдгийг журамд заасны дагуу ашиглаж байна.

Тайлант оны эхэнд 3 ажилтнаас нууцын баталгаа гаргуулан авч, төрийн нууцад хамаарах Зэвсэгт хүний ангиудын санхүүгийн тайланг нууцын ажилтнаар дамжуулан хүлээн авч холбогдох аудиторуд аудит хийж, материалыг нууцын ажилтан нууцын архивд хадгалан тухай байгууллагад аудит хийгдсэн тайланг хүргүүлэв.

Байгууллагын архив, албан хэргийг архивын хууль тогтоомжийн дагуу баримт хадгаламжийн нэгжийг заасан хугацаанд зохион байгуулалтын нэгж, ажилтнуудаас хүлээн авч, архивлаж байгаа ба санхүү, гүйцэтгэл, нийцлийн аудитын ажлын баримтыг архивлан, үдэж цэгцлэх ажил хийгдэв.

Хамт олны санаачилгаар “Хамт олны хуримтлалын сан”-г бий болгон сар бүр 20.0 мянган төгрөгийг цалингаас суутгуулан, тодорхой хэмжээний мөнгөн хуримтлалтай болж, албан хаагчдын гачигдал зовлон, зарим нийгмийн асуудлыг шийдвэрлэж байна.

Албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, ажлын стресс тайлах, өвлийн улиралд ханиад томуунаас урьдчилан сэргийлж, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор санхүүгийн тайлангийн аудитын ачаалал ихтэй 1-3 дугаар саруудад өдөр бүр халуун аарц, чацарганаар үйлчилгээ үзүүлэн 0.3 сая төгрөгийг албан хаагчдын бие эрүүл мэндэд зориулан зарцуулсан. Ахмадуудаа хүлээн авч хүндэтгэл үзүүлэв.

Ковид-19 гарсантай холбоотой МУЕА-ын А/83 тоот тушаал гарсны дагуу дотооддоо ажлын төлөвлөгөө гаргаж, Тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулан, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Аудитын тайланг олон нийтэд мэдээлэхээр Adobe master коллекцын photoshop, in design, premiere pro программуудыг шинээр нэвтрүүлж эхлээд байна.

БҮЛЭГ-8

АУДИТЫН МӨРӨӨР ХИЙСЭН АЖИЛ

Урд оны болон 2020 оны аудитаар тавигдсан акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн явцад хяналт тавьж, биелэлтийг хангах ажлыг зохион байгуулав.

Энэ хүрээнд: Аудитын багуудын аудиторуд хариуцсан аудитынхаа мөрөөр ажиллаж, биелэлтийг хангуулахаар албан тоот хүргүүлэх, утсаар ярих, аудитыг газар дээр нь үзэх зэргээр ажиллав. Нэгдсэн удирдамж, орон нутгийн захиалгат аудитын явцад сумдад болон байгууллагуудад өгсөн акт, албан шаардлагын биелэлтийг талбар дээр үзэж, баталгаажуулж ажилласан.

Актын дутуу 78.2 сая төгрөгийг барагдуулахаар аймгийн Прокурорын байгууллагад холбогдох нотлох баримтыг хүргүүлээд байна.



БҮЛЭГ-9

САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ:

Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, тогтоомжийн дагуу явуулан улирал, жилийн тайлан балансаа хугацаанд нь гаргаж, Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангуулж, шилэн дансны цахим хуудаст мэдээллийг хууль журамд заасан хугацаанд нь байршуулж байна.

Тус газар нь 2020 онд 542.7 сая төгрөгийн санхүүжилттэйгээр үйл ажиллагаагаа явуулж, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж ажилласан.

Төсвийн тухай хуулийн дагуу сар бүр төсвийн гүйцэтгэлийн мэдээ, өр авлагын мэдээ гаргаж, эхний хагас жилийн өмч хөрөнгийн тооллогыг явуулсан.

Байгууллагын 2019 оны санхүүгийн тайланд Grant Thornton Audit компаниар санхүүгийн тайлангийн аудитыг хийлгэж, “Зөрчилгүй” дүгнэлт авсан.

БҮЛЭГ-10

ДҮГНЭЛТ, САНАЛ

Санхүүгийн тайлангийн аудит:

Санхүүгийн тайлангийн аудитаар 147 байгууллагад зөрчилгүй, 8 байгууллагад “Хязгаарлалттай” дүгнэлтийг өгч, “Сөрөг” болон “Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан” дүгнэлт гараагүй байна.

Аудитаар нийт 308 төрлийн 4283.3 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлэн 101 төрлийн 2445.9 сая төгрөгийн алдаа зөрчлийг аудитын явцад залруулж, 9 төрлийн 6.3 сая төгрөгийн акт тавьж, 8 төрлийн 5.8 сая төгрөгийн актыг барагдуулан биелэлт 92.1 хувь, 54 төрлийн 608.2 сая төгрөгийн албан шаардлага өгснөөс 53 төрлийн 599.5 сая төгрөгийн албан шаардлагыг хэрэгжүүлэн биелэлт 98.6 хувь, 130 төрлийн 1222.9 сая төгрөгийн зөвлөмж өгснөөс 126 төрлийн 1050.3 сая төгрөгийн зөвлөмжийг хэрэгжүүлэн биелэлт 96.9 хувьтай байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар байгууллага, аж ахуйн нэгжид үр өгөөж тооцсоноор 6.3 сая төгрөгийн аудитын үр өгөөжийг бүртгэн тухайн байгууллагуудын удирдлагаар хүлээн зөвшөөрүүлэв.

Санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэсэн байгууллага, аж ахуйн нэгж, сангуудын үе шатны ажлуудыг СТАУС программд 100.0 хувь оруулсан.

Санхүүгийн тайлангийн аудитын бодлого чиглэлийн дагуу 8 асуудлын хүрээнд хийсэн танилцуулга дүгнэлтээс үзэхэд: Төсөвт байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн боловсруулалт, шинэчлэлт, мөрдөлт учир дутагдалтай, төсөвт байгууллагуудын санхүүгийн программууд ойр ойрхон солигдож, ашиглагдаагүй бүртгэлтэй биет бус хөрөнгүүд ихэссэн байна. Программын ашиглалт ч сайнгүй байна.



Гүйцэтгэлийн аудит:

Гүйцэтгэлийн аудитаар ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар 4 сэдвийн, аймгийн ИТХ-ын хүсэлт, захиалга болон өөрийн санаачилгаар 3 сэдвийн, нийтдээ 7 сэдвийн хүрээнд аудит хийж, давхардсан тоогоор 159 байгууллага, сумдыг хамруулан 2 төрлийн 83.5 сая төгрөгийн акт өгснөөс 1 төрлийн 10.7 сая төгрөгийг хэрэгжүүлж, биелэлт 12.8 хувьтай, 12 төрлийн 4491.3 сая төгрөгийн албан шаардлага өгснөөс 6 төрлийн 3998.6 сая төгрөгийн албан шаардлагыг барагдуулж, биелэлт 89.0 хувь, 38 төрлийн буюу 5290.0 сая төгрөгийн зөвлөмж өгсний 26 зөвлөмж буюу 5290.0 сая төгрөгийг хэрэгжүүлж, биелэлт 100.0 хувьтай хэрэгжсэн байна.

Тус аудитаар 16 төрлийн 5500.8 сая төгрөгийн үр өгөөж хүлээн зөвшөөрүүлсэн.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтад хийсэн аудитаар дараах үр дүнд хүрсэн байна. Үүнд:

- ✚ Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжсэн төсөл, арга хэмжээний хувьд хөрөнгө оруулалтын шинж чанартай бус төсөл, арга хэмжээг төлөвлөж, батлуулахаа зогсоосон.
- ✚ Төсвийн Ерөнхийлөн захирагчдаас тайлант онд эрх шилжсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг хэрэгжих боломжтой хугацаанд эрх шилжүүлдэг болсон.
- ✚ Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт өмнөх онуудаас өссөн үзүүлэлттэй байна.
- ✚ Их засварын болон барилга угсралтын ажлын ихэнхийг зураг төсвийн дагуу хийгдсэн байна. Захиалагч, зохиогч, мэргэжлийн байгууллагын хяналтаар илэрсэн зөрчлийг гүйцэтгэгчээр тухай бүрд нь арилгуулах арга хэмжээ авсан байна.
- ✚ Төсөл, арга хэмжээний санхүүжилтийн ихэнхийг бодит гүйцэтгэлд үндэслэн, хугацаанд нь олгодог болсон байна.
- ✚ Гүйцэтгээгүй ажилд санхүүжилт илүү олгогдохыг таслан зогсоосон.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн аудитын үр дүнд:

- ✚ Хөрөнгө оруулалтын ТАХ-ний хэрэгцээ шаардлагыг оновчтой тодорхойлж, ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолтыг хууль, журам, стандартын дагуу боловсруулж хэвшиж байна.
- ✚ Хөрөнгө оруулалтын ТАХ-г хүлээн авахдаа тендерт шалгарсан болон гэрээнд заасан техникийн тодорхойлолт, үзүүлэлт, тоо хэмжээтэй тулган үзэж, зөрүүтэй тохиолдолд гүйцэтгэгчид буцааж шаардлага хангасан бараа, ажил, үйлчилгээг авч ажилласан.

Баянтээг ХК-ийн 2019 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн аудитаар компани үйл ажиллагаагаа үндэслэлтэй төлөвлөж, уулын ажлын төлөвлөгөөг ТЭЗҮ-дээ нийцүүлэн боловсруулах болсон нь чухал ололт болсон. Мөн маркшейдерийн гаргасан тооцооллын алдааг аудитын явцад илрүүлэн аудиторчуудын зүгээс залруулга хийж ажилласан нь үр дүнтэй ажил боллоо.

Нийцлийн аудит:

Нийцлийн аудитаар ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар 2 сэдэв, УИХ, аймгийн ИТХ болон өөрсдийн санаачилгаар 5 сэдэв, нийтдээ 7 сэдвийн хүрээнд аудит хийж, давхардсан



тоогоор 245 байгууллага, сумдыг хамруулж, 1 төрлийн 2.3 сая төгрөгийн акт тавьснаас 1 төрлийн 2.3 сая төгрөгийн актыг барагдуулж, биелэлт 100.0 хувьтай, 23 төрлийн 54064.8 сая төгрөгийн албан шаардлага тавьснаас 19 төрлийн 53841.6 сая төгрөгийг барагдуулж, биелэлт 99.6 хувьтай, 21 төрлийн 570.1 сая төгрөгийн зөвлөмж өгснөөс 15 төрлийн 570.1 сая төгрөгийн зөвлөмж хэрэгжиж, биелэлт 100.0 хувьтай гарсан байна.

Тус аудитаар 2 төрлийн 1270.6 сая төгрөгийн үр өгөөж тооцож хүлээн зөвшөөрүүлсэн.

Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд жил бүр аудит хийгдэж, дүгнэлт, зөвлөмж өгч ажилласнаар: Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч хувийн цэцэрлэгүүд шилэн дансанд цэс нээлгэн мэдээллээ тогтмол мэдээлдэг болсон, Төсвөөс хөрөнгө оруулалтын санхүүжилт авсан аж ахуйн нэгж, байгууллагууд захиалагчтай гэрээ байгуулахдаа гэрээнд шилэн дансанд мэдээлэл байршуулах талаар тусган ажилладаг болсон үр дүн харагдаж байна.

"ОНХС-ийн 2019 оны хөрөнгийн зарцуулалт"-д хийсэн аудитын үр дүнд хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах болон хөрөнгө орлогот аваагүй зөрчлүүд бүрэн арилсан байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажлууд орон нутгийн иргэдэд үр өгөөжөө өгч, иргэдийн ая тухтай амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлсэн олон ажлууд хийгдсэн байна.Тухайлбал:

Сум болгон камержуулалд хийгдсэнээр иргэдийн амгалан тайван байдал хангагдаж, хулгай дээрэм багассан. Бүх суманд цэцэрлэгт хүрээлэн байгуулагдаж хүүхэд багачуудын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, таатай орчин бүрджээ.

Аймгийн төв дээр усан спортын төв, кино театр байгуулагдсанаар иргэдийн чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, цаашид соёлын талаар авч хэрэгжүүлж байгаа томоохон арга хэмжээ болж, үр дүнгээ өгсөн ажлууд хийгдсэн байна.

Арвайхээр цэцэрлэгжилт ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны үр дүнд : Арвайхээр суманд нийтийн эзэмшлийн талбайд 76.0 сая төгрөгийн тарилт ургалтгүй болсон байсныг нөхөн зүлэгжүүлэлт хийлгэсэн. Зөвлөмж өгсний үр дүнд орлогын төлөвлөгөөг ТУЗ-өөрөө зардал тус бүрээр төлөвлөн батлуулж орлого бүрдсэн байна.

ТАГ-ын 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу санхүүгийн болон гүйцэтгэл, нийцлийн аудитыг төлөвлөсөн хугацаанд хийж, дүгнэлт, зөвлөмжөө өгч ажилласан.

Аудитаар байгууллага, аж ахуйн нэгжид үр өгөөж тооцсоноор 27 төрлийн 6777.7 сая төгрөгийн аудитын үр өгөөжийг бүртгэн тухайн байгууллагуудын удирдлагаар хүлээн зөвшөөрүүлэн, төсвөөс авсан санхүүжилтийн 1 төгрөгийн хариуд 12 төгрөг 49 мөнгөний үр өгөөж бий болгосон байна.

Санал:

1. Хүний нөөцийн бодлого, үйл ажиллагааны талаар:

- ТАБ-ын хүний нөөцийг бүрдүүлэхдээ Төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, ажлын туршлага, мэдлэг, хандлага, ур чадвар, сахилга, хариуцлага, мэргэшлийн байдлыг харгалзан шударга ёс, ил тод, тэгш байдал, мерит тогтолцоо, мэргэшсэн тогтвортой байдал, хараат бус бие даасан байдал зэрэг хуульд заасан зарчмуудыг баримталдаг байх.
- Хүний нөөцийг цаашид чадавхжуулах, тогтвортой ажиллуулахын тулд сурч хөгжих боломж, гүйцэтгэлд суурилсан урамшуулал, албан хаагчдын нийгмийн баталгаа, ажлын байрны орчныг сайжруулах, ажлын байрны эрүүл ахуй, тохижилт соёлжилт,



даатгал, эрүүл мэндийг хамгаалах хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж үе шаттай хэрэгжүүлэх, шаардлагатай хөрөнгө, нөөцийг байгууллагын төсөвт жил бүр тусган зориулалтын дагуу зарцуулж байх.

- ҮАГ-аас мэргэжил, арга зүйгээр тухай бүр, түргэн шуурхай хангах, стандарт, хууль, тогтоомж, шийдвэрийн шинэчлэл, өөрчлөлтийг тухай бүр цаг алдалгүй орон нутагт хүргүүлж байх.

2. Мэдээллийн технологийн талаар.

- Орон нутгийн хувьд интернэтийн хурдыг нэмэгдүүлэх, дотоод сүлжээний доголдлыг арилгах
- Аудитын төрөл тус бүрд мэдээллийн технологи, программ хангамжийг ойрын хугацаанд нэвтрүүлэх.

ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦСАН:

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

О.БАТЖАРГАЛ

ТАЙЛАНГ БОЛОВСРУУЛСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ГАНСҮХ

2020-12-18